

**Улаанбаатар хотын хүйтний улирлын агаарын чанарын төлөв байдал
/2022 оны 3 дугаар сар/**


Улаанбаатар хотын агаарын чанарыг гэр хороолол, автозам, орон сууцны хороолол, үйлдвэрийн дүүрэг орчмын 15 цэгт агаар бохирдуулах бодис болох хүхэрлэг хий (SO₂), азотын давхар исэл (NO₂), PM_{2.5}, PM₁₀ тоосонцор, нүүрстөрөгчийн дутуу исэл (CO), озон (O₃) болон цаг уурын үзүүлэлтүүдийг автомат багажаар тодорхойлж байна.

2022 оны хүйтний улирлын 3 дугаар сарын Улаанбаатар хотын агаар дахь агаар бохирдуулах бодисын дундаж агууламжийг өмнөх оны мөн үеийн дундаж агууламжтай харьцуулахад PM₁₀ тоосонцор 7 мкг/м³-ээр буюу 7%-иар бага, PM_{2.5} тоосонцор 2 мкг/м³-ээр буюу 6%-иар, хүхэрлэг хий 10 мкг/м³-ээр буюу 14%-иар, азотын давхар исэл 4 мкг/м³-ээр буюу 11%-иар тус тус их байна.

Бохирдуулах бодисын нэр	Агаарын чанарын стандарт MNS 4585:2016	Дундаж агууламж, мкг/м ³	
	Хүлцэх агууламж, мкг/м ³	2021 оны 3 дугаар сар	2022 оны 3 дугаар сар
PM ₁₀ тоосонцор	100	102	95
PM _{2.5} тоосонцор	50	34	36
Хүхэрлэг хий, SO ₂	50	72	82
Азотын давхар исэл, NO ₂	50	37	41

Улаанбаатар хотын сүүлийн 5 жилийн хүйтний улирлын гол бохирдуулах бодис тус бүрийн агууламжийг дараах хэсэгт харуулав.


PM₁₀ тоосонцор



Зураг 1. Хүйтний улирлын PM₁₀ тоосонцрын сарын дундаж агууламж, 2017-2022 он

Агаар дахь PM₁₀ тоосонцрын 2022 оны 3 дугаар сарын дундаж агууламжийг 2021 оны мөн үеийн дундаж агууламжтай харьцуулахад 7%-иар бага, Агаарын чанарын стандарт MNS 4585:2016 дахь хүлцэх агууламж /цаашид АЧС дахь ХА гэх/-аас хэтрээгүй байна (Зураг 1).


PM2.5 тоосонцор



Зураг 2. Хүйтний улирлын PM2.5 тоосонцрын сарын дундаж агууламж, 2017-2022 он

Агаар дахь PM2.5 тоосонцрын 2022 оны 3 дугаар сарын дундаж агууламжийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6%-иар их, АЧС дахь ХА-аас даваагүй байна (Зураг 2).


Хүхэрлэг хий (SO₂)



Зураг 3. Хүйтний улирлын хүхэрлэг хийн сарын дундаж агууламж, 2017-2022 он

Улаанбаатар хотын агаар дахь хүхэрлэг хийн 2022 оны 3 дугаар сарын дундаж агууламжийг 2021 оны мөн үетэй харьцуулахад 14%-иар их, АЧС дахь ХА-аас 1.6 дахин их байна (Зураг 3).

Азотын давхар исэл (NO₂)



Зураг 4. Хүйтний улирлын азотын давхар ислийн сарын дундаж агууламж, 2017-2022 он

Азотын давхар ислийн 2022 оны 3 дугаар сарын дундаж агууламжийг 2021 оны мөн үетэй харьцуулахад 11%-иар их, АЧС дахь ХА-аас хэтрээгүй байна (Зураг 4).

ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР
ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС